

Түүхэн харьцуулсан хэл шинжлэлийн хүрээнд
туслах үгийн айг авч үзэх нь
(Түрэг, монгол хэлний жишээгээр)

Лувсандоржийн БОЛД¹

Монгол Улс, Улаанбаатар, Шинжлэх Ухааны Академи,
Хэл зохиолын хүрээлэн, Харьцуулсан хэл шинжлэлийн салбар

Submitted: September 25, 2025 | **Accepted:** November 15, 2025

Хураангуй: Энэхүү өгүүлэлд эртний түрэг хэлнээс орчин цагийн түрэг хэлэнд уламжлагдан ирсэн дагавар үгийн бүтэц, тэдгээрийн монгол хэлтэй холбогдох байдалд дүн шинжилгээ хийв. Үүнтэй зэрэгцэн орчин цагийн монгол хэлний дагавар үгийг монгол бичгийн хэлний хэрэглэгдэхүүнтэй харьцуулан авч үзлээ. Өдгөө бидэнд уламжлан ирсэн монгол бичгийн хэлний томоохон дурсгалуудын хэл нь монгол хэлний хөгжлийн түүхийг үечилсэн эрдэмтдийн судалгаагаар дундад эртний монгол хэлний үед хамаарагддаг. Гэвч энэ үеийн дурсгалуудын хэл зүйг бүхэлд нь хамарсан цогц судалгаа одоогоор хийгдээгүй байна. Харин тухайн үеийн дурсгалуудын үгийн сан, зарим хэл зүйн бүтээврийг хамарсан лавлах шинжтэй бүтээлүүд нэлээд гарсан бөгөөд тэдгээрт тулгуурлан энэхүү судалгааг хийв. Өгүүлэлд монгол хэлний туслах үгийн хэлбэр зүйн асуудалд голлон анхаарч, дагавар үгийн талаарх цуглуулсан баримтад үндэслэн үгийн бүтцийн түвшинд дагавар үгийг үүсмэл ба эс үүсмэл гэж ангилан, мөн үгсийн аймгийн үгийг дагавар үгийн үүргээр хэрэглэсэн тохиолдлуудыг онцлон авч үзэв.

Түлхүүр үг: монгол хэл, түрэг төрөл хэл, үгсийн аймаг, туслах үг, дагавар үг

A Historical-Comparative Linguistics Study of Category of Function Words
(Based on Examples in Mongolian and Turkic languages)

BOLD Luvsandorj

*Department of Comparative Linguistics, Institute of Language and Literature,
Mongolian Academy of Sciences, Ulaanbaatar, Mongolia*

¹ © Л.Болд, 2025

Email: boldl@mas.ac.mn

Abstract: *This article examines the structure of postpositions inherited from Old Turkic into modern Turkic languages and their relationship with the Mongolian language. In addition, postpositions in Modern Mongolian are analyzed through comparison with materials from the written Mongolian language. According to scholarly periodization of the historical development of the Mongolian language, the language of the major extant written monuments belongs to the Middle Mongolian period. However, to date, no comprehensive study has fully covered the grammatical system of the monuments from this period. Nevertheless, a considerable number of reference materials addressing the vocabulary and, in some cases, grammatical constructions of these monuments have been published, and these sources form the basis of the present study. The article focuses on the morphological study of function words in Mongolian and, based on the collected data on postpositions, classifies postpositions at the level of word structure into derived and non-derived types. Special attention is also paid to cases in which words from other parts of speech are used with the function of postpositions.*

Keywords: *Mongolian language, Turkic languages, parts of speech, function words, postpositions*

1. Удиртгал

Аливаа хэлний (монгол, түрэг хэлнүүдийг онцлов Л.Б) туслах үгийн тухай ярина гэдэг нь чухамдаа бүтэц өгүүлбэрийн бүрэлдэхүүнд орсон үгсийг үгийн сан, хэл зүйн онцлогийг нь харгалзан бүлэглэн ангилсан үгсийн аймгийн тогтолцоонд түүний эзлэх байр суурийг тодорхойлон хэлэлцэхээс эхэлнэ гэдэг нь хэн бүхэнд ойлгомжтой буй заа. Үгсийг аймаглан авч үзнэ гэдэг нь тухайн хэлний хэл зүйн гол зангилаа асуудлын нэг мөн боловч, хэрэг дээрээ энэ нь ямар хэцүү болохыг монгол хэл шинжлэлийн түүх бидэнд нотлон харуулдаг билээ.

Гэвч, хэл судлаачид энэ шийдвэрлэх асуудалд эдүгээ хүртэл анхаарлаа хандуулсан хэвээр байна. Өнөөдөр бидний ярилцахаар зорьж буй сэдэвтэй холбогдуулан үзвэл гадаад дотоодын үе үеийн эрдэмтдийн туурвисан эл асуудалд зориулсан бүтээлүүдээс уламжлалт хэл шинжлэлийн аргаар бүтэц өгүүлбэрийн бүрэлдэхүүнд орсон үгсийг зэрэгцүүлэх биш шатлан хуваасан ангилалд туслах үгийг үгсийн аймгийн нэг болгон авч үзсэн зарчим (Искаков Пальмбах, 1961: 429-462., Кононов, 1980: 200-208) арга зүйн хувьд илүү нийцтэй мэт санагдана. Ийм чиглэлийн судалгаанд туслах үгийг үгсийн аймгийн системд бие даасан нэг аймаг болгон үздэг авч, үүнээ цааш нь сул үг, дагавар үг, холбоос үг гэж дэд ай болгон авч үзсэн байдаг (мөн тэнд). Сүүлийн үед монгол хэл шинжлэлийн хүрээнд эрчимтэй нэвтэрч буй бүтэц хэл шинжлэлийн аргад тулгуурлан монгол хэлний үгсийг аймаглан үзсэн судалгааны бүтээлд “... монгол хэлний үгсийг юуны өмнө утга, хэлбэр үүргээр нь гол үг, туслах үг гэж хоёр том бүлэгт хуваан ангилна (Өнөрбаян, 2004: 166)” гээд туслах үгээ дотор нь бас холбоос үг, чимэх үг гэсэн хоёр дэд ай болгон ай тус бүрийн онцлог шинжийг нь тодорхойлон бичсэн байна. Түрэг, монгол хэлний үгсийг аймаглан үзсэн эдгээр эрдэмтдийн нэг тал нь уламжлалт хэл шинжлэлийн аргаар, нөгөө нь бүтэц хэл шинжлэлийн аргаар тухай тухайн

хэлнийхээ үгсийн аймгийг авч үзсэн боловч, туслах үгийг нийтэд нь үгсийн нэг аймаг болгон үзэж, үүнээ цааш нь бас дэд ай болгон авч үзсэн зарчим нь адилхан байна. Ялгаатай нь гэвэл түрэг судлалын эрдэмтэд туслах үгээ дагавар үг, холбоос үг, сул үг гэж ангилсан бол манай эрдэмтэд холбоос үг, сул үг буюу чимэг үг гэж ангилсан ажээ.

2. Судалгааны арга зүй

Бид уг хоёр хэлний үгсийг хэл шинжлэлийн янз бүрийн аргад тулгуурласан дээрх эрдэмтдийн саналыг анхааран үзэж, хэл бол ертөнцийн бусад аливаа юмс, үзэгдлийн адил шууд болон шууд бус замаар өөр хоорондоо шүтэн барилдаж байдаг боловч ерөнхий, хийсвэр, түгээмэл шинжээрээ нэгдэж тодорхой нэгэн анги бүлэгт хамаарагддаг, тэр нь бас тусгай, бодитой, тодорхой чанараараа эсрэгцдэг гэсэн түгээмэл зарчимтай холбон туслах үгийг авч үзнэ. Өөрөөр хэлбэл бүтэц өгүүлбэрийг бүрдүүлэхэд оролцож буй үгсийг анхааран үзвэл гүйцэтгэх үүрэг, илэрхийлэх утга, хэл зүйн харьцаанд орсон байдлаараа харилцан адилгүй байдаг билээ. Үүнийг сайтар мэдэхийн тулд эхлээд үг гэдэг тодорхойлолтыг авч үзэх шаардлагатай хэдий ч энэ асуудал монгол хэл шинжлэлийн хүрээнд төдийгүй ерөнхий хэл шинжлэлийн хүрээнд ч нэгдмэл нэг ойлголтод одоогоор хүрч чадаагүй, харин түүний гол шинж чанарын тухай ярилцах нь боломжтой юм. Үүнд: 1. Үг нь бодит утгатай буюу үгийн сангийн нэрийтгэл утгатай байна. Жишээлэхэд *морь*, *хонь* гэхэд гэрийн тэжээмэл тодорхой амьтны нэрийг зааж байгаа бол, *явах ирэх* гэхэд үйл, тодорхой хөдөлгөөнийг зааж байна. Үүнчлэн *тав*, *арав* гэхэд тодорхой тоог зааж, *улаан хар* гэхэд бодис юмны өнгийг илэрхийлсэн утгатай байна. 2. Үг нь бүтэц өгүүлбэрийн дотор орохдоо тодорхой асуултад хариулагдаж чадна. Энэ нь өгүүлбэрийн бие даасан гишүүний үүрэг гүйцэтгэж чадаж байгаагийн илрэл юм. 3. Үг нь тэмдгийн үүрэг гүйцэтгэж чадах авианы тодорхой байрлалд орсон бүрэлдэхүүнтэй байна. Энэхүү авианы байрлалыг өөрчлөх, солиход өөр утга илэрхийлэх буюу эсвэл бүр тодорхой утга илэрхийлэхгүй, авианы бөөгнөрөл болдог байна. 4. Үг нь бие даасан үгийн гол шинж болсон өргөлттэй байна. 5. Бүтэц өгүүлбэрийн бүрэлдэхүүнд орсон үг нь янз бүрийн харьцаа илэрхийлдэг нэр үгийн болон үйл үгийн нөхцөл авсан байна. Үүнтэй холбогдуулан монгол хэл зүйч нарын бүтээлд дурдагдсан охь болсон нэгэн өгүүлбэрийн утгыг задлан үзвэл дараах байдалтай байна. *Үсүг-ий хурийажу нер-е болоху нер-ий хурийажу үге болоху үсүг-ийер удха-ий үзегүлкү тер чаг-тур нөкүсел керегтей болой* (Балданжапов, 1962: 46). Энд дурдсан нэр томъёог орчин цагийн хэлэнд хөрвүүлбэл *үсүг* гэдэг нь *авиалбар*, *нер-е* гэдэг нь *үг*, *үге* гэдэг нь *өгүүлбэр*, *нөкүсел* гэдэг нь *үг хувилгах бүтээвэр* гэсэн үг болно. 6. Үг нь үг бүтээх дагавар авч үгийн сангийн шинэ нэгж үүсгэж чадна. Жишээлбэл, *хонь* (гэрийн тэжээмэл бог мал) + *чин* > *хоньчин* (хонь хариулдаг хүн, малчин) г.м. *Дуу минь*, *ярианы ба бичгийн хэлээ маш сайн эзэмшихийн тул шамдан суралцаарай*. гэсэн бүтэц өгүүлбэрийн дотор орсон үгсийг ажиглавал *ба*, *тул*, *маш* гэдэг үгээс бусад үгс нь бидний дээр өгүүлсэн үгийн бүх шинж чанарыг бүрэн агуулсан байна. Гэвч *ба*, *тул*, *маш* гэсэн энэ гурван үг нь тус өгүүлбэрийг

бүтээхэд онцын үүрэггүй гээд хасвал энэ өгүүлбэр ямар ч утгагүй болох нь хэн бүхэнд тодорхой буй за. Иймд тус өгүүлбэрийг бүтээхэд эдгээр үг чухал үүрэгтэй болох нь ойлгомжтой. Ийм үзэгдэл зөвхөн орчин цагийн монгол утга зохиолын хэлэнд байдаг зүйл биш түрэг, монгол хэлнүүдэд бас түгээмэл байдаг зүйл юм.

Энд судалгааны судлагдахуун болгон авч үзэж байгаа хэлнүүдээс хэдэн жишээ авч үзвэл ... *ama sagan qula-yi minu nirugu-yi inu qarugsan-u tula jebe kemen nereyidcu ...* (Орловская, 1984: 193) ... *ам цагаан хул /морь/-ын минь нурууг хавасны тул чамайг Зэв хэмээн нэрийдэж ...*, буриад хэл: бороотой үдур байсан тула - бороотой өдөр байсан тул, аман болон уран зохёол - аман зохиол болон уран зохиол, халимаг хэл: асхн *күртл* йовий - *орой болтол явъя, эс медх - үл мэдэх*, эртний түрэг хэл: *inim kul tigin birle sozlesdimiz* (Ktb26) - *дүү Күлтегиний хамт зөвлөлдөв. uze kok Tengri* (Ktb1) - *дээр хөх тэнгэр*, тува хэл: *хар дег ак - цас шиг цагаан*, үш чүс *хире* өөреникчи - *гурван зуу орчим сурагч* г.м. Эдгээр жишээ өгүүлбэрт орсон налуу үсгээр ялган бичсэн туслах үгийг ажиглавал өмнө өгүүлсэн үгийн шинжүүдээс тодорхой байрлалд орсон авианы бүрэлдэхүүн, мөн үгийн гол шинж болсон өргөлт хоёроос бусад бүх шинжийг агуулаагүй боловч өгүүлбэр бүтээхэд чухал үүрэгтэй байгаа нь тодорхой байна. Өөрөөр хэлбэл эдгээр бүх үгэнд буй түгээмэл шинж бол өгүүлбэрт бие даасан гишүүний үүрэг гүйцэтгээгүй, хэл зүйн янз бүрийн харьцаа илэрхийлдэг нөхцөлөөр хувираагүй, үгийн сангийн бодит утга илэрхийлээгүй, өмнөх үгтэйгээ нийлж байж сая утга нь тодорхой болж байгаа бөгөөд энэ шинж дээр нь тулгуурлаад эдгээр үгийг ‘туслах үг’ хэмээн үзсэн байна. Гэхдээ эдгээр үгэнд ийм нийтлэг шинж байгаа боловч бүтэц өгүүлбэрийн бүрэлдэхүүнд орохдоо харилцан адилгүй үүрэг гүйцэтгэж байна. Үүнийг тодорхой тайлбарлахын тул орчин цагийн монгол утга зохиолын хэлнээс жишээ авсан эхний өгүүлбэрт анхаарлаа дахин хандуулах хэрэгтэй болно. Уг өгүүлбэрийн бүтцэд орсон *ба* гэдэг үг нь тухайн өгүүлбэрт орсон зэрэгцсэн гишүүн өөрөөр хэлбэл *ярианы хэл, бичгийн хэл* гэсэн адил гишүүдийг зааглах, бас холбох үүрэг гүйцэтгэж байна. Гэтэл *тул* гэдэг үг нь үүнээс өөр үүрэг тухайлбал, тухайн үйлийн зорилгыг заасан утгыг илтгэж байх жишээтэй. *Маш* гэдэг үг нь ардаа орсон тэмдэг нэрийнхээ утгыг эрчимжүүлсэн баймж утга илэрхийлж байна. Хэдийгээр эдгээр үгс үгийн сангийн биеэ даасан бодит утга илтгэхгүй, өгүүлбэрт тодорхой гишүүний үүрэг гүйцэтгэхгүй, хэл зүйн элдэв хувиллаар хувирахгүй гэх зэрэг ерөнхий, түгээмэл, хийсвэр шинжээрээ адилхан байгаа боловч, өгүүлбэрт гүйцэтгэх үүргээрээ эрс ялгаатай байна. Энэ байдал дээр нь тулгуурлавал туслах үгийг 1. дагавар үг 2. холбоос үг 3. сул үг буюу чимэг гэж ангилсан зарчим зөв байна. Иймээс эдгээр дэд ай тус бүрийн талаар авч үзэх нь тус өгүүллийн зорилго юм.

3. Дагавар үг

Орчин цагийн монгол хэлний тийн ялгалыг түрэг хэлний тийн ялгалтай зөвхөн тоотой нь харьцуулан үзэхэд тодорхой харагддаг. Тухайлбал монгол хэлэнд 1. нэрлэх, 2. харьяалах, 3. заах, 4. өгөх орших, 5. гарах, 6. үйлдэх, 7.

хамтрах, 8. зүг чиглэл заах гэсэн үндсэн найман тийн ялгал, үүн дээр орчин цагт хэрэглээ нь бага болсон хэмжээ хязгаар заасан тийн ялгал, холбохын тийн ялгалыг нэмбэл лавтайяа арван тийн ялгал байна гэж үзэх боломжтой. Гэтэл түрэг хэлнүүдэд тийн ялгал нь харьцангуй цөөн, үүний жишээг орчин цагийн тува хэлний тийн ялгалаар төлөөлүүлэн үзүүлбэл 1. нэрлэх, 2. харьяалах, 3. өгөхийн, 4. заахын, 5. орны, 6. гарахын, 7. зүг чиг заах гэсэн долоон тийн ялгал байдаг.

Гэвч орон цаг, учир шалтгаан, зорилго болон бусад харьцааг нарийвчлан илэрхийлэхэд дагавар үг чухал үүрэг гүйцэтгэдэг. Энэхүү дагавар үг нь өмнө өгүүлсэн үгийн шинж чанаруудаас тодорхой авианыхаа бүрхүүлийг хадгалж, бие даасан бодит утгатай үгийн адил үгийн гол шинж болсон өргөлтөө алдаагүй, иймээс өмнөх үгтэйгээ эгшиг зохицдоггүйгээрээ гол үгтэй адил боловч, бие даасан өгүүлбэрийн гишүүн болж чаддаггүй, үгсийн хоорондын харьцаа илэрхийлдэг талаараа нөхцөлтэй адил үүрэг гүйцэтгэдэг. Дагавар үгийн энэ мэт шинж чанар нь бүтэц өгүүлбэрийн бүрэлдэхүүнд орохдоо илүү тод илэрдэг.

Эртний түрэг хэл: *jir saji bardig (Ktm 9) -(Аяа, та нар) газар сайгүй тэнүүчлэв. qanim qagan susi bori teg ermis yagisi qoy teg ermis /Ktb 12/ -тэр тулалдаанд /манай хаан цэрэг чоно шиг, дайсны цэрэг хонь шиг байв. ol sub qodi bardibiz /T 27/ -тэр голыг уруудан очлоо бид/ бид тэр гол руу очив, ozum tardus bodun uze sad ertim /Ktb 17/-Тэр үед би тарагчид түмний шад байв”.*

Тува хэл: мен сен-биле кады чоруур мен - би чамтай хамт явна, хемни *кежилдыр* хөмүрүг тургускан –голын дээгүүр гүүр тавьсан, даг дег караны довук дег ак базар /зүйр үг/ - уул шиг харыг тойг шиг цагаан дийлэх, үш чүс *хире* өөреникчи - гурван зуу орчим сурагчид.

Монгол хэл: ...хуучин сар орой гарах тул алс замын чигийг олж ядна /Д.Нацагдорж/. ...шөнө *туриш* зогсохдоо өрөөсөн хөлөө ганц удаа сольсон билээ. Өмнө биеэр хэрэн давхих гөрөөс долгион мэт өнгөрнө / Д.Нацагдорж/. Чи 2 дугаар сарын 25 *хүртэл* эндээ бай. Хорь *шахам/шахуу* хүн цугларчээ.

Буриад хэл: Тэрэ *дороо* Гомбые ерүүлбе - тэр *дороо* Гомбыг ирүүлэв, мэнэ *дороо* - тэр *даруйдаа*, хүн мэтэ зугаалдаг- хүн шиг ярьдаг, наһан *соогоо* хүниие заража үзөөгүй - *насан туришдаа* хүн зарж үзээгүй, хэдэн *һара соо* - хэдэн сарын *туриш*, тэнгэри өөдэ хараха - тэнгэр лүү харах, халимаг хэл: герин эзн герген мини ардас орж ирэд үүднэ түс суув. - *Гэрийн эзэгтэй миний араас орж ирээд үүд хавьд суу, худг деер* ирхлэ... *худаг дээр ирэхэд...*, асхн *күртл* гермүд эргэд хоюрн йовии - *орой болтол гэрээ эргээд хоёул явъя.* г.м.

Дагавар үг нь бие даасан үгийн сангийн нэрийтгэл утгагүй тул өгүүлбэрт гишүүний үүрэг гүйцэтгэж чаддаггүй болохыг өмнө нь дурдсан бөгөөд харин өгүүлбэрийн гишүүдийн хоорондын харьцааг илэрхийлэхэд чухал үүрэгтэй болохыг дурдсан жишээ баримтаас үзэхэд тодорхой байна. Иймд тухайн өгүүлбэрийн бүрэлдэхүүнээс дагавар үгийг нь хасаж болохгүй, хэрвээ хасвал уг өгүүлбэр тодорхой утгагүй болох, эсвэл найруулгын хэм хэмжээ нь алдагдахад хүрч байна. Үүнийг арай илүү ойлгомжтой болгох үүднээс хэдэн жишээг задлан үзье. Хэрэв эртний түрэг хэлний жишээнд орсон *teg* гэсэн тэмдэг нэрийн хийсвэр зэрэг илэрхийлэх утгатай дагавар үгийг авчихвал *манай хааны цэрэг чоно, дайсны цэрэг хонь*. гэсэн утгагүй буюу өөр өгүүлбэр болж байна. Үүнчлэн

буриад хэлний жишээ өгүүлбэрт орсон “*дороо*” гэсэн дагавар үгийг нь хасвал *Тэр Гомбыг ирүүлэв*. гэхэд бүр өөр утгатай өгүүлбэр болж байна. Эх өгүүлбэрт “*тэр дороо*” гэсэн үг нь цаг хугацаа зааж байгаа бол дагавар үгийг нь хассанаар “*тэр*” гэсэн заах төлөөний үг үндсэн утгаараа хэрэглэгдэх болж, эх өгүүлбэрт орсон өгүүлбэрийн гишүүдийн үүрэг ихээхэн өөр болж байна. Үүнчлэн халимаг хэлний *худг деер ирхле* гэсэн өгүүлбэрт орсон “*деер*” гэсэн дагавар үгийг нь хасвал “*худг*” гэсэн үг нь өгүүлэгдэхүүн гишүүний харьцааг илэрхийлэх болж, уг өгүүлбэрийн утга бодит байдалд үл нийцэх болж байна.

Энэ баримт нь дагавар үг нь хэдийгээр дангаараа байхдаа үгийн сангийн бодит утгагүй авч, өмнөх үгтэйгээ нийлж байж түүний утга тодорхой илэрч байгаа хэрэг юм. Монгол хэлээр жишээлэн хэлбэл *морь, хонь* гэхэд тодорхой утгатай байна, гэтэл *сайн сурахын тул хичээлээ давтах хэрэгтэй, долоо найм хэрийн настай хүүхэд, наадам хүртэл амарна* гэх мэтийн өгүүлбэрт орсон *тул, хэрийн, хүртэл* гэх мэтийн дагавар үгэнд ийм бодит утга байхгүй харин өмнөө орсон үгтэйгээ нийлбэл түүний утга тодорхой болох бөгөөд энэ үедээ өгүүлбэрийн гишүүнийг илрүүлэх асуултад оногдож, өгүүлбэрийн ямар ч гишүүний үүрэг гүйцэтгэж чадаж байна. Энэ бол дагавар үгийн өгүүлбэр зүйн үндсэн шинж даруй мөн. Дагавар үгийн хэл зүйн шинжтэй холбогдуулан бодох өөр нэг зүйл бол зарим дагавар үг тийн ялгалаар хувирч болдог явдал юм. *Энэ мэтийн, энэ мэтийг, энэ мэтээр, энэ мэтээс, энэ мэтэд, энэ мэттэй, энэ мэт рүү* г.м. Энэ үзэгдэл нь тухайлбал *морь, хонь* гэх мэтийн бодит утгатай үг тийн ялгалаар хувирдагтай харьцуулан үзвэл их өвөрмөц шинжтэй бөгөөд анхааралтай үзвэл ард нь орсон үгийг хураасан тохиолдолд гарсан үзэгдэл гэж үзэж байна. Бүтэц хэл шинжлэлийнхний нэр томъёог ашиглан хэлбэл цөмийг дагуул үгээр нь төлөөлүүлж буй хэрэг гэж бодож байна.

Дагавар үг нь бие даасан тодорхой хэлбэртэй, холбогдох бусад үгтэйгээ нийлэхээрээ илэрдэг өвөрмөц тодорхой утга илэрхийлж чадаж байна. Иймээс дагавар үгийг хэл зүйн үүднээс авч үзэхийн зэрэгцээ түүний утга зүйн шинжийг нь харгалзан үзэх нь хэлбэр, агуулгыг тэгш харгалзан үзсэн судалгаа болох билээ. Дагавар үгийн хэлбэрийг анхааран үзнэ гэдэг маань чухамдаа нэг талаас түүнийг үгийн бүтцийн түвшинд авч үзнэ гэсэн хэрэг бөгөөд энэ нь түүний үүсэл хөгжлийг мэдэхэд ихээхэн тустай зүйл ажгуу. Ер нь хэлний хөгжлийн чиг хандлагыг анхааран үзнэ гэдэг нь зөвхөн өнөөгийн байдлыг зөв ухаарахад ихээхэн тус нэмэр болохын гадна, ирээдүйн хөгжлийн зүг чигийг зөвөөр төсөөлөхөд үлэмжхэн ач тустай юм Иймд бид эхлээд түрэг хэлний дагавар үгийн бүтэц, тэр нь монгол хэлтэй хэрхэн холбогдох талаар товч өгүүлээд дараа нь монгол хэлний дагавар үгийг үгийн бүтцийн түвшинд авч үзнэ .

3.1. Түрэг хэлний дагавар үг

Эртний түрэг хэл: *ara* (дунд, хооронд, завсар) уул үгийг *ar* – отделять (ДТС: 50) гэдэг үг нөхцөл үйл үгийн -а хэлбэрээс үүссэн гэж үздэг (Кононов, 1980: 201) ажээ. Монгол хэлний *арал* гэдэг үгтэй холбогдож магадгүй. *oguz ara jeti eren jagi bolti* (O5) - *Огуз /түмний/ дундаас долоон эр /бидний/ дайсан болов, uze kok tengri asra jagiz jer qilintuqda ekin ara kisi ogli qilinmis* (Ktb 1) - *дээр хөх тэнгэр дор бараан газар үүдсэний /учир/ энэ хоёрын завсар хүний хүү бий болов.*

г.м. Эртний түрэг хэлэнд идэвхтэй хэрэглэгддэг *qodi* гэдэг үг дагавар үгийн нэг юм. *ol sub qodi bardimiz* (T27) - *тэр гол уруу очигцоов бид.*, *selengge qodi jorigan* (M37) - *Сэлэнгэ рүү явцгаав. Сэлэнгийг уруудан явцгаав.*, тува хэл: куду : өнг бажын куду-, орукту куду - *зам уруу, зам уруун*, сугну куду - *гол уруу, гол руу*” (Щербак, 1987: 80). Энэ үг бие даасан үгийн үүргээр бас хэрэглэгдэнэ. *Куду* билиг - *бага боловсрол, куду өртек - доод үнэ* (TRC, 1968: 202). Тофалар хэл: *тоьш куду чжораан - мөс руу очьё, чер куду - газар уруу, уруу газар.* г.м. Харин уйгар - урианхай хэлэнд энэ дагавар үг нь зүг чиг заах нөхцөл болсон байдаг. *Өвгедэ - гэр лүү, даггада - уул руу* г.м. Энэ бол монгол хэлний нөлөө байж болно. Гарал зүйнхээ үүднээс энэ үг нь орчин цагийн монгол хэлний *гудайх* (аливаа юмны нэгэн этгээд хажуу тийшээ жиших, доошлох), *гударган* (юмны толгой цээжний зүг хөнтөргөн, хэлтгий), *гутрах* (ямар нэгэн буурал тохиолдох, доройтох гутрах), *худаг* (газрыг эрж гаргасан устай нүх) (Цэвэл, 1966) зэрэг үгтэй холбоотой гэдэг боловч утгын тэнцүү чанарынхаа хувьд монгол бичгийн хэлний *уруу* (уруу газар, уулын уруу) гэдэг үгтэй илүү ойр байна. Ийнхүү адилтган үзэх нэг шинж бол монгол бичгийн хэлний энэ үг орчин цагийн монгол хэлэнд бие даасан үгийн гол шинжийн нэг болсон өргөлтөө алдан өмнөх үгтэйгээ эгшиг зохицох болсны улмаас тодорхой байрлалд орсон авианыхаа бүрэлдэхүүнийг өөрчилсөн явдал юм. Жб., *гар луу, уул руу* г.м. Иймээс орчин цагийн монгол хэлэнд наймдугаар үндсэн тийн ялгал бүрэлдэн тогтсон гэж үздэг билээ (Лувсандэндэв. 2017: 136-140).

Эртний түрэг хэл: *inim Kultigen birle sozlesdim* (Ktb260) - *дүү Күлтегентэй зөвлөлдөв.*, *Sik bodun qirqiz birle jagi bolti* (M26) - *Чикийн харьяат түмэн Киргизүүдийн хамтаар бидний дайсан болов.* гэх мэт. Уг *birle* үгийн гарлыг *big + le* (< *lep* нөхцөл үйл үгийн нөхцөл) гэж тайлбарладаг авч бид арай өөр өнцгөөс авч үзмээр байна. Энэ үг нь *big* “нэг+ *le*” (< * *lig*) гэсэн бүтэцтэй байж болно. Уг үгийн бүтцэд оролцсон гэж үзэж буй < * *lig* гэдэг бүтээвэр нь монгол хэлний *урлаг, баялаг* гэх мэт үгийн бүтцэд оролцсон *-лаг* (<**lig*) бүтээврийн нэгэн хувилбар мөн хэмээн таамаглаж байна. Зарим судлаачид үүнийг эс зөвшөөрч эртний зүүн Түрэг Улсын хаан Эльтириш хааны хоёр дахь хүүгийн нэрийг өөрөөр тайлбарлахыг санал болгодог бөгөөд энэ учраа “-l” гийгүүлэгчийн дараа “-i” эгшиг тохиолдохгүй гэсэн зарчмаар тайлбарладаг билээ. Гэвч эртний түрэг хэлний бүрэн хэл зүйг бичсэн академич А.Н.Кононов өөрийн бүтээлдээ энэ бүтээвэр нь “-li, -lig” гэдэг хоёр хувилбартай болохыг Орхон бичгийн дурсгалаас жишээ татан өгүүлсэн байдаг (1980: 107). *illig bodun ertim* (Ktb9) (холбоотон /улстай/ ард түмэн билээ би), *inili esili* (Ktb6) - *дүүтэй, өвөг дээдэстэй* г.м. Иймээс эртний Хөх Түрэг улсын цэргийн жанжин, хун тайжийн өргөмж нэр Күли тегин /алдарт тегин/ хэмээх галиг нь биднийг алдаанд хүргэхгүй юм.

Тува хэл: *мен сен биле* кады чоруур *мен - би чамтай хамт явна*, олар арыгда орук *биле* келгеннер - *тэд нар уулын замаар ирцгээнэ.*, тофалар хэл: Алёошка *биле* каьты келген -*Алёошкатай хамт ирсэн*, динг кельни *биле* даараан дон - *хэрэмний арьсаар оёсон /өвлийн/ дээл*, уйгар-урианхай хэл: *мен онгоча бле* келген *мен - би онгоцоор ирсэн*, карандаш *биле - харандаагаар* г.м.

Эртний түрэг хэл: *qangim susi boru teg ermis jagisi qoj teg ermis* (Ktb12) -*Хаан эцгийн минь цэрэг нь чоно шиг, дайсны /цэрэг нь/ хонь шиг байлаа. ... oguli*

qangin teg qilinmaduq erinc (Ktb5) - хүү нь эцэг шигээ хүмүүжээгүй бөлгөө. гэх мэт. Энэ үгийн гарал монгол хэлний *teng* (тэн хагас адил, тэнцүү хуваасан зүйлийн хагас нь), *tengcegui* < *teng* + *ce* + *gui* (яг адил) гэдэг үгийн язгууртай холбоотой ажээ.

Тува хэл: хар *deg* ак - *цас шиг цагаан*, тофалар хэл: сен мен *deg* бол - *чи над шиг болоорой*. г.м. Түрэг хэлний дагавар үг бол эртний түрэг хэлний *tapa* юм. *Jazinga oguz tapa suledim* (M31-32) – (тэр жилийнхээ/ намар нь огуя руу цэрэглэв би) ... *ilgeru qitang tatabi bodun tapa birgeru tabgac tapa ulug su eki jeigmi sungusdim* (Ktb28) – (...өрнө зүг хятан, татабийн харьяат түмэн рүү, хойт зүг табагач рүү их цэрэг /илгээж/ арван хоёр /удаа/ тулалдав). Энэ удаад судлагдахуун болгон авч үзэж байгаа түрэг хэлнүүдэд ийм хэлбэр утгатай дагавар үг тэмдэглэгдсэнгүй шиг байна.

Тува хэлэнд “-*тува*, -*түве*, -*тыва*, -*тиве*/-*дыва*, -*диве*, -*дува*, -*дүве*” гэсэн хэлбэртэй зүг чиг заах тийн ялгалын нөхцөл идэвхтэй хэрэглэгдэж байна. *Дагдыва* (уул руу), *кижидиве* (хүн рүү), *оттува* (гал руу), *хүндүве* (нар луу) г.м. Орчин цагийн казак хэлэнд эртний түрэг хэлний *tapa*, тува хэлний зүг чиг заах тийн ялгалын өмнө дурдсан нөхцөлтэй авианыхаа бүрхүүлийн болон утгын хувьд ч тун ойролцоо *таман* гэдэг үг бий бөгөөд толь зүйч Б. Базылхан үүнийг “чигт, зүгт, -руу/-рүү” гэсэн утга илэрхийлдэг *тауга таман кету* (уулын зүгт явах) гэжээ (Базылхан, 1977: 295). Орчин цагийн монгол хэлэнд тооны нэр болон утга зүйн талаасаа их ойр утга илэрхийлдэг *олон*, *цөөн*, *хэсэг* гэх мэт үг, мөн орны утга илэрхийлдэг *цаад*, *наад* зэрэг үгийн ард тохиолддог *-таа*, *-тоо*, *-тээ*, *-төө* бүтээвэр байдаг билээ. *Арвантаа* – (арван удаа), (Цэвэл, 1966: 49). *Голын тэртээх манан гогцоорон байж үзэгдэнэ /дууны үгээс/. Малын толгой цөм л зүүнтээ харж үдлэх дөхөж буй бололтой /Л.Түдэв/. ...Хиагтын Гэсэр сүм, баруунтаа буй ширээт бурхны сүм, Алтанбулагийн хоршоогоор хэсдэг байлаа. /Б.Ринчен/ ... энэтээ уулын орой дээр хөхөө шувуу донгодохуй яа.../Д.Нацагдорж/ г.м. Я.Цэвэл авгайн хийсэн тайлбараас үзвэл тооны нэрийн ард тохиолдох *-таа* бүтээвэр нь яав ч өгөх оршихын тийн ялгалын харьцаа илэрхийлэх нөхцөл биш гэж болно. Харин жишээ авсан дууны үгэнд гарах *тэртээ* гэдэг үгийн бүтцэд орсон *-тээ* бүтээврийг тийн ялгалын харьцаа илэрхийлж байна гэж үзэх үндэслэлтэй гэж үзэхийн учир нь уг бүтээврийн ард түрэг, монгол хэлэнд хамаатуулахын утга илэрхийлдэг *-х* (< *- *qi*) нөхцөл орсны учир болой. Үүнийг *манай-х*, *танай-х* гэх мэт үгийн бүтэцтэй харьцуулан үзвэл ойлгомжтой. Байрлал хэл шинжлэлчдийн үзэхээр хамаатуулахын нөхцөл нь ямагт тийн ялгалын хойно тохиолддог гэж тайлбарладаг билээ. *Гар минь өвдөөд* гэвэл *гар* гэдэг үг нь нэрлэхийн тийн ялгалд байна хэмээн тайлбарладаг, тиймээс хойноо хамаатуулахын нөхцөл авч чадаж байна. Тэгвэл *арван-таа*, *тэр-тээ-х*, *цаад-таа*, *зүүн-тээ*, *энэ-тээ* гэх мэт үгсийн бүрэлдэхүүнд орсон *-таа*, *-тээ* бүтээврүүд бүгд гарлынхаа хувьд холбоотой юу гэдэг асуудал зүй ёсоор урган гарч байна. Энэ асуултад холбоотой гэж хариулах нь зүйтэй. Учир нь эртний түрэг хэлний *tapa* хэмээх дагавар үг нь монгол хэлэнд хоёр өөр үүрэг, бүр тодруулбал үг бүтээх дагавар, нөгөө нэг хувилбар нь зүг чиг заах харьцаа илэрхийлэх нөхцөл болсон байна гэж болно. Үүнтэй холбогдуулан нэмж хэлэхэд өгөх оршихын тийн ялгал *-аа/-**

ээ, *-д/-т* гэсэн хоёр хувилбартай байдаг шиг зүг чигийн тийн ялгал хоёр хувилбартай байж болох юм.

Эртний түрэг хэлний “Ol qan joq boltuqta kesre... (O1) - *Тэр хан үгүй болсны дараа*, anta kesre inisi qagan bolmis erinc (Ktb 45) - *түүний дараа дүү нь болов.*” гэсний *kesre* хэмээх үгийн язгуур нь *kes-*, *kis-*, *ked-*, *ket-*, *kic-*, *kes...* гэсэн олон хувилбартай бөгөөд *-ra/-re* бүтээврийг эртний түрэг хэлний өгөх чиглэхийн тийн ялгалын нөхцөл (Кононов, 1980: 205) гэж үздэг ажээ. Монгол, түрэг толиудаас үзвэл энэ үг казак хэлэнд *кей* гэдэг хэлбэртэй бөгөөд “онан *кейн* - *түүний дараа* (Базылхан, 1984: 175)” гэх мэт холбоо үгэнд оролцож байна. Энэ жишээнээс үзвэл тус үг туслах үгийн үүргээр биш гэдэг нь тодорхой. Өмнө дурдсан уул үгийн язгуурын олон хувилбарууд монгол үгийн бүтцэд олонтоо тохиолдож байгаа нь анхаарал татаж байна. Эхлээд “МНТ”-оос жишээ авч үзье. *jiči guči ügülejü ile’et yadaju ö’esün be’en gedün otju ügülerün* (167) – *жич гуч өгүүлж илээгээд ядаж өөсөн (өөрөө) бэгэн гэдэн одож өгүүлдүүн*, *usun-u qarki-tur gedergü kebtejü* (149) ...*усны харигт гэдэргэ /дээш/ хэвтэж ...*, *jebe-yin gejige Sübe’eteу-yi ilebei* (257) – *Зэвийн гээгэ Сүвээдэйг илгээж буй* (Мөнхсайхан, 2020: 488-489). *Гэдийх* (гэдгэр болох), *гэдгэр* - (юмны хэвийн жишээнээс гэдэргэн байдалтай), *гээгэ* – (хүний толгойн тайч, танаагүй урт ургуулсан үс) (Цэвэл, 1966: 168). Олонх монгол хэл судлаачид энэ сүүлчийн үгийн язгуурт орсон эртний монгол хэлний хамжих гийгүүлэгч хамжин шүргэх гийгүүлэгч болсны үр дүнд үүссэн гэж үзсээр ирсэн билээ. Өмнө өгүүлсэн жишээнээс үзвэл орчин цагийн монгол хэлний дээрх үг нь лавтайяа хэлэхэд дундад эртний монгол хэлэнд байсан *gejig* гэдэг дагавар үгээс уламжлан ирсэн үг хэмээн үзэхэд хүргэж байна. Утга зүйн талаас нь үзвэл бие даасан үгээс дагавар үг болдог гэдгийг бид өмнө нь нэгэнтээ өгүүлсэн бөгөөд харин энд уул процесс эсрэгээрээ болсон гэж үзэхэд хүргэж байна. Өөрөөр хэлбэл энд дагавар үгээс тодорхой зүйлийг нэрлэсэн нэр үүссэн шиг байна. Ер нь ийм үзэгдэл, бүр тодруулбал үгсийн хоорондын харьцаа илэрхийлдэг бүтээврээс дагавар үг үүсэж болох уу гэдэг асуулт тавигдах бөгөөд үүнд цөөн боловч байж болох талтай гэж хариулбал зохилтой. Үүнийг *дэлхий дахин* гэдэг холбоо үгийн бүрэлдэхүүнд орсон *дахин* гэдэг үг нь өгөх оршихын тийн ялгалын *-да* нөхцөл, хамаатуулах утгатай *-хи* бүтээвэр хоёроос үүссэнтэй харьцуулан үзэж болох юм.

3.2. Монгол хэлний дагавар үг

Монгол хэлний дагавар үг *metü* нь олон тооны нөхцөл авсан хэлбэрээр, мөн төлөөний үгийн дараа орсон байдлаар нэлээд тохиолддог. *temüjin kö’ün-tür qatqulduqun metüs ket büi* /170/ - *Тэмүүжин хөвгүүнд хатгалдахуй мэтэс хэд (хэн хэн) буй* /?/, ...*narat metüs deu-ner-i čin-u* /245/ - *нарад мэтэс дүү нэрий чинь* (Мөнхсайхан, 2020) г.м. Монгол бичигт *metü* нь бусад дагавар үгээс дундад эртний монгол хэлэнд хамгийн идэвхтэй хэрэглэгдэж байна. Тухайлбал, С.Мөнхсайханы боловсруулсан толиос үзвэл энэ дагавар үг нь зөвхөн “МНТ”-д нийтдээ 69 удаа тохиолдож байна. “МНТ”-д *kö’üt inu mene metü törebe* /41/ – *хөвгүүд нь мэнэ мэт төрөв*, *qahan aqa-yi aqta metü songquju irge metü bilijü* /272/

- хаан ахыг агт мэт сонгож иргэ мэт билиж..., *niji'el müsüt metü ken-e ber kilbar-a ququldaqun ta /22/ - ннжээл мөсөд мэт хэнээбээр хялбараа* хугалдахуй *та, ... šira noqai metü sačabaljaу qarqu büle'e /21/ - ... шар нохой мэт шазвалзаж гарах билээ* гэж гардаг. Эхний өгүүлбэрт орсон *qatqulduqun* гэдэг үг нь *qatquldu-* гэдэг үйл үгийн үйлт нэрийн ирээдүй цагийн олон тоог заасан хэлбэр бөгөөд уг үгийн ганц тооны хэлбэр нь *-qui* хэлбэртэй байдаг билээ. Дараагийн өгүүлбэрт орсон *narat* гэдэг үг нь *нарс* (*нарс гэдэг модоор наадмыг минь сийлсэн аав минь*) /ардын дуунаас/ гэдэг үгийн олон тооны нөхцөл юм. Иймд бичгийн хэлэнд тодотгогч, тодотгуулагч хоёр тоогоор зохицдог ёс байсан тухай судлаачид олонтоо тэмдэглэсэн байдаг авч, энд тэр харьцааг *metü* гэдэг дагавар үг аль алиных нь харьцааг илэрхийлээгүй атал олон тоог зааж байгаа нь зөвхөн хэл зүйн учир холбогдлын үүднээс тайлбарлагдах зүйл юм.

Орчин цагийн монгол хэлэнд аливаа хоёр зүйлийг адилтгах ерөнхий утгаа хадгалж идэвхтэй хэрэглэгддэг энэ дагавар үг нь гол төлөв нэрийн айд хамаарах үгсийн дараа байрладаг. Бусад дагавар үгстэй харьцуулан үзвэл тийн ялгалын бүх харьцааг илэрхийлж байгаа мэт харагдавч тэр нь чухамдаа ардаа орсон нэрийн айг хураасан, өөрөөр хэлбэл дагуулаар нь цөмийг нь орлуулсан тохиолдолд л ингэж чаддаг байна. *Энэ мэт юм, энэ мэтийн, энэ мэтийг, энэ мэтэд, энэ мэтээр, энэ мэтээс, энэ мэттэй, энэ мэт рүү* г.м. Энэ бол уул үг нь гол төлөв хоёр нэрийн айн үгсийг адилтгах, жиших харьцааг илэрхийлдэг уул үгийн утга, үүрэгтэй холбоотой байдаг онцлогтой холбон тайлбарлагдах зүйл хэмээн үзэж байна. *Тэнгэрийн тэр сүрт дуу чимээ дайны цагийн их бууны тэсрэлт мэт сонсогдож байлаа* (Б.Ширэндэв). *Зул мэт бадмалан жаргахуй* (Д.Пүрэвдорж). *Гагцхүү эрт нэрд гарч, олон хүн дайлж хүндэтгэдгээс болоод настай ахмад хүн мэт санагддаг байж л дээ* (Ш.Сүрэнжав) г.м. Буриад хэлэнд уһанай хоёр дуһал мэтэ адлинууд - *усны хоёр дусал шиг адилхан*, толи мэтэ тэгшэ - *толь шиг тэгшхэн*, эсэгэ мэтэ энхэргэнээр - *эцэг мэтэ энхрийлэн /хайрлах/* г.м. (БРС,1973: 313). Халимаг хэлэнд, усна хойр дусал мет эдл - *усны хоёр дусал мэт адил*, ээсн мет бээх - *айсан мэт байх* г. м (КРС.1977: 351).

Монгол бичигт *šig* хэлбэртэйгээр тэмдэглэгдсэн авч бидний сонирхон үзэж буй үеийн бичгийн дурсгалд үүнээс арай өөр (Лигети, 1969: 339) *šinggi, šitü* гэсэн хэлбэртэйгээр илэрдэг ажээ. “МНТ”-д *qaqša kö'ün min-u ügei šitü /164/ - гагц хөвүүн минь үгүй шиг, salqu šitü nuntaq /255/ - салах /хол/ шиг нутаг* гэж гардаг. Гэхдээ “МНТ”-ы баримтаас үзвэл дээрх хоёрхон жишээнд энэ дагавар үг оролцсон байна. Орчин цагийн монгол хэлний энэхүү дагавар үг нь өмнө өгүүлсэн үгийн адил нэрийн айд хамаарагдах хоёр зүйлийг өөр хооронд нь жишин харьцуулах үндсэн утгаараа хэрэглэгдэж байна. *Ус шиг цэнхэр, өд шиг хөнгөн, утас шиг нарийхан* г.м.

Монгол хэл шинжлэлд бүтэц хэл шинжлэлийн арга хүчтэй дэлгэрч энэ аргад тулгуурлан монгол хэлний уламжлалт хэл шинжлэлийн дэгээр бичсэн олон үзэгдлийг өөрөөр тайлбарлаж байна. Ийм зүйлийн нэг нь энд дурдаж буй *шиг* гэдэг дагавар үгийн тухай юм. Бүтэц хэл шинжлэлчид энэхүү дагавар үгийг ардаа үг бүтээх дагавар авдаггүй, мөн цагт нэрийн дараа үг бүтээх дагавар ордоггүй гэх зэрэг үндсэн шалгуур үзүүлэлтээр уг үгийг нөхцөлийн айд хамруулж, үүнийгээ жишихийн тийн ялгал хэмээн нэрлэж байна. Харин ийн үзэгсэд *шиг*-тэй яг ижил утга үүрэгтэй *мэт* гэдэг үгийн талаар ер өгүүлсэнгүй.

Энэ *шиг*, *мэт* нь өгүүлбэрт гүйцэтгэх үүрэг, байрлалаараа яг адилхан. *Явсан мэт санагдана.*, *Энэ мэтээ мартуузай.* г.м. Энэ хоёр үг дагавар үгийн гол шинж болсон авианы бүрхүүл нь өөрчлөгдөөгүй, үгийн гол шинжүүдийн нэг болсон өргөлтөө алдаагүй байгаа байдал нь уул үгсийг дагавар үгийн бүрэлдэхүүнд хамааруулан үзэх гол шалгуур болж байна. *Ахынхаа хэлснийг бүү мартаарай.*

- *Ах шигээ хүн болоорой, Багшийгаа хүндэл.* - *Багш шигээ хүндэл* г.м. Хэрвээ *шиг* гэдэг нь нөхцөл юм бол өмнөх өгүүлбэрт орсон *ахынхаа, багшийгаа* гэдэг үгийн адил нэгдүгээр үед орсон өргөлтөт эгшигтээ захирагдан эгшиг зохицох хуульд захирагдах ёстой. Дараагийн жишээнд орсон *ах шигээ, багш шигээ* үгэнд оролцсон ерөнхийлөн хамаатуулахын “-ээ” нөхцөл нь *ах, багш* гэдэг үгийн “а” эгшигтэй зохицохгүй байгаа нь *шиг* гэдэг үг өргөлтөө алдаагүй байгаа хэрэг юм. *Бат гүнд сууж байхдаа дүүтэй нь хамт Говь мэргэн Вангийн сүргээс таслан хөөж Цэцэн Сартуулын хошуунд дамжуулж байсан нэгэн эртэй дайралдаж Төмөрийн тухай өдий төдий домог шиг яриа сонсжээ* (Ч.Лодойдамба). *Усны шувуу шиг дэвэн дэвэн одлоо* (Д.Нямаа). *Хүн ээжийгээ мөнх юм шиг санаж явдаг хойно доо* (Ч.Чимид) г.м.

Л.Лигети *metü, žitü* гэдэг дагавар үг нь *žinggi* -тэй гарал зүйнхээ үүднээс холбогдох тухай өгүүлснийг өмнө нэгэнтээ дурдсан билээ. Буриад хэл зүй зохиогчид уул дагавар үгийн илтгэх утгыг орос хэлний “подобно”, “как”-тай тэнцэнэ хэмээн үзсэн байна (ГБЯ,1962: 313). *харанхы хүни шэнги -харанхуй шөнө шиг*, *балтаар цохихон шэнги -сүхээр цохьсон шиг*, *табан хурган шэнги мэдэхэ ёготой -таван хуруу шигээ мэдэх ёстой* г.м.

Монгол бичигт *tula, tulada* хэмээн тэмдэглэгдсэн энэ хоёр үг гарал зүйнхээ үүднээс холбоотой, гэхдээ үгийн эцэст тохиолдож байгаа “-да” дагавар нь өгөх оршихын тийн ялгалын дагавартай холбоогүй. Харин “-д” дагавар орон цагийн нэр үүсгэдэг “-та, -тэ/-да, -дэ” -тай илүү холбогдоно. *Үүрд* (< egure + -de;) *гэнэт* (<gene/?/ + -te) г.м. Түүхэн баримтад *tula* гэдэг хэлбэр нь арай илүү тохиолдож байгаа нь уул үгийг арай хожуу үүсэж хэрэглэгдэх болсныг илтгэнэ. “МНТ”-д энэ үг нь 41 удаа гарч байхад *tulada* гэсэн хэлбэр нь ер тохиолдохгүй байх жишээтэй. МНТ-д *noyamšiq abiratu tula Noyakin obuqtan bolba /46/ - ноён шиг авиртай тул Ноёхон овогтон болов, minu tula aqa de'ü-tür mawuqalin bolulča'ujai /31/ -миний тул ах дүүд муухалин бололцуузай, aqa de'ü ja'uga adaruqči tula adargin oboqtan bolba /46/ - ах дүү зуураа адрагч /ааштай/ тул адархин овогтон болов* гэж гардаг. Орчин цагийн монгол хэлэнд энэхүү дагавар үгс нь хэрэглэгдэх агуулгын хүрээгээрээ онцын зөрүүгүй шиг байна. *Онц сурахын тул хичээлээ сайн давт - Онц сурахын тулд хичээлээ сайн давт.* г.м. Харин бичгийн хэлэнд найруулгын ялгавартай хэрэглэгдэхийг үгүйсгэх аргагүй. Одоогоор бидний бүрдүүлсэн бүрэн гүйцэт биш баримтаас үзвэл *тул* гэдэг дагавар үг нь үйлийн шалтгаан заасан утгаар хэрэглэгдэж байна. *Нөгөө Хочлайг барьж цаазлах гэхэд Бэг-Арслан түүнийг нуун далдалсан тул хэчнээн эрэн сурвалжлавч бараа туруугүй арилжээ.* (Ш.Нацагдорж), *Нөгөө улаан бух хэчнээн шороо цагавч мөргөлдөх зүрх тэн ирсэнгүй тул цээлхэн дуугаар урамдан үнээнүүдийн хойноос яваад өглөө.* (С.Эрдэнэ), *Бас л хүн байсангүй тул машиныхаа дэргэд эргэн ирж сүүдэрт нь тамхиа татав.* (С.Дагдоргов) г.м.

Харин тулд гэдэг дагавар үгийг тухайн үйлийн зорилгыг зааж байна хэмээн үзэж болох талтай. *Гэвч өвдсөн хүнийг эдгээхийн тулд эм өгөхдөө саналыг нь*

асуудаггүй тул (Л.Ванган), Дамбий гадаа гарч Лүндэг эмээд харагдаж лай удахгүйн тулд байшингийн ард сүүдэр бараадах дүр үзүүлэн суулаа. (Л.Түдэв) г.м. Үүнийг цаашид нарийвчлан судлууштай. Энэ дагавар үг буриад хэлэнд тула гэсэн хэлбэртэйгээр идэвхтэй хэрэглэгдэж байна. Бороотой үдэр байһан тула - бороотой өдөр байсан тул, мэргээр буудаһан тула - мэргэн буудсан тул г.м.

Монгол хэлний *төлөө* хэмээх үгийг “МНТ”-ы баримтаас үзвэл харьцангуй хожуу үед монгол бичгийн хэлэнд хэрэглэгдсэн бололтой байдаг. Орчин цагийн монгол хэлэнд энэ дагавар үг нь өмнө өгүүлсэн дагавар үгийн адил зорилго заасан утгаар хэрэглэгдэх нь нэлээд түгээмэл байна. *Хайрт эх орныхоо төлөө, Сонгогчдынхоо эрх ашгийн төлөө ажиллах нь миний эрхэм үүрэг болно. Энэ төрийг байгуулахын төлөө миний эцэг амиа алдсан юм. (С.Доржпалам) г. м.* Буриад хэлэнд Талынгаа Бүргэдэй түлөө - талынхаа Бүргэдийн төлөө, арба сагаанай түлөө - арван цагаан буяныхаа төлөө, хайн ябаынтнай түлөө - сайн явахын тань төлөө, халимаг хэлэнд Би зөвин төлэ шачасн халас чигн ээшгов - Би зөвийн төлөө шатсан галаас ч айхгүй, Тана көвүнтн күмн эмтнэ жирһлин төлэ баатр зөрмг өнгрв - Таны хүү чинь хүн амьтны жаргалын төлөө баатарлаг зоримог хэвээрээ байсаар өнгөрөв. г.м. Энэ мэтээр цаашид монгол хэлний *тухай, туриш, хүртэл* гэх мэт олон дагавар үгийг нарийвчлан тайлбарлах хэрэгцээ бий.

Үргэлжлэл дараагийн дугаарт

4. Дүгнэлт

Орчин цагийн монгол хэлнүүдэд хэрэглэгдэж байгаа олонх дагавар үгсийг үгийн бүтцийн үүднээс авч үзвэл үүсмэл байх нь олонтоо тохиолдож байна. Иймээс цаашид монгол хэлнүүдэд харьцангуйгаар түгээмэл хэрэглэгддэг, бас өмнөх үеийн эрдэмтэд судалгааны эргэлтэд оруулсан баримт хэрэглэгдэхүүнд тулгуурлан дүн шинжилгээ хийх шаардлага үүсдэг.

Монгол, түрэг хэлнүүдийн хэл зүйн хөгжлийн ерөнхий чиг хандлагыг үгийн бүтцийн түвшинд авч үзвэл бие даасан үгээс дагавар үг, түүнээс үг бүтээх дагавар болон улмаар нөхцөл болж хөгждөг ерөнхий зүй тогтолтой. Үүнийг уг хэлнүүдийн дагавар үгийн хөгжлийн жишээнээс илүү тод харж болно. Орчин цагийн монгол хэлний наймдугаар үндсэн тийн ялгал гэж үзэж байгаа зүг чиг заах тийн ялгалын *-руу, -рүү/-луу, -лүү* нь монгол бичгийн хэлний *urugu* “уруу” гэдэг дагавар үгээс үүсэлтэй билээ. Мөн монгол хэлний өгөх-оршихын тийн ялгалын нөхцөл *-д, -т* нь түрэг болон манж хамниган хэлтэнд уул нөхцөлтэй үүрэг, утга, авианы бүрхүүл нь тун ойролцоо хэлбэртэй бол солонгос хэлэнд энэ нь “*орших газар, байр*” гэсэн утгатай нэр үг байдаг. Энэ бүхний дүнд орчин цагийн монгол хэл нь үгсийн хоорондын харьцаа илэрхийлдэг тийн ялгалын нөхцөлөөр баялаг гэж хэлж болохоор байна. Энд өгүүлж буй бидний судалгаанд ийм жишээ цөөнгүй байгаа тул хойшид мөн дэлгэрэнгүй авч үзнэ.

Санхүүжилт: Тус өгүүллийг ШУТС-аас санхүүжүүлж буй “Алтайн хэлнүүдийн хэл зүйн харьцуулсан судалгаа-Туслах үгийн аймгийн жишээгээр” (зөвшөөрлийн дугаар: ШУСс-2024/22) суурь судалгааны төслийн хүрээнд хийж гүйцэтгэв.

Ном зүй

- Базылхан, Б.** (1977). *Казак монгол толь*. Улаанбаатар. [Bazykhan, B. *Kazak mongol toli* [Kazakh - Mongolian dictionary]. Ulaanbaatar, 1977]
- Базылхан, Б.** (1984). *Монгол казак толь*. Улаанбаатар. [Bazykhan, B. *Kazak mongol toli* [Mongolian - Kazakh dictionary]. Ulaanbaatar, 1984]
- Балданжипов, В.** (1962). *Монгольские грамматическое сочинение, XVIII века*, Улан-Удэ [Baldanjipov, V. *Mongolian grammatical work of the 18th century*. Ulan-Ude, 1962]
- БРС**, (1973). *Бурятско-русский словарь*, составил В.М.Черемисов, Москва. [Buryat - Russian Dictionary, compiled by V. M. Cheremisov. Moscow, 1973]
- ГБЯ**, (1962). *Грамматика бурятского языка /фонетика и морфология/*, Москва. [Grammar of the Buryat language (Phonetics and morphology). Moscow, 1962]
- ГКЯ**, (1983). *Грамматика калмыцкого языка /фонетика и морфология/*, Элиста. [Grammar of the Kalmyk language (Phonetics and morphology). Elista, 1983]
- Исхаков, Ф.Г., Пальмбах, А.А.** (1961). *Грамматика тувинского языка /фонетика и морфология/*, Москва. [Isakov, F. G., & Palmbakh, A. A. *Grammar of the Tuvan language* (Phonetics and morphology). Moscow, 1961]
- Кононов, А.Н.** (1980). *Грамматика языка тюркских рунических памятников VII-IX вв.*, Ленинград. [Kononov, A. N. *Grammar of the language on the Turkic runic monuments, 7th - 9th centuries*. Leningrad, 1980]
- КРС**, (1977). *Калмыцко-русский словарь*, /ред. Б.Д.Муниева/. Москва. [Kalmyk - Russian dictionary, edited by B. D. Munieva. Moscow, 1977]
- Лувсандэндэв, А.** (2017). *Монгол үндэсний утга зохиолын хэл бүрэлдэн тогтсон нь*, Улаанбаатар. [Luvsandendev, A. *Mongol undesnii utga zokhiolyn khel bürelden togtson ni* [Formation of the language of Mongolian literature]. Ulaanbaatar, 2017]
- Мөнхсайхан, С.** (2020). *Монголын нууц товчооны үгийг эшлэн үзүүлсэн толь*, Улаанбаатар. [Munkhsaikhhan, S. *Mongolyn nuuts tovchoony ügiig eshlen üzüülсэн toli* [A Dictionary illustrating the words on the Secret History of the Mongols]. Ulaanbaatar, 2020]
- Орловская, М.Н.** (1984). *Язык "Алтан товчи"*, Москва. [Orlovskaya, M.N. *The Language of the 'Altan Tobchi'*. Moscow, 1984]
- ОЦМХЗ**, (1966). *Орчин цагийн монгол хэлний зүй /хамтын/*, Улаанбаатар. [Orchin tsagyn mongol khelnii züi [Grammar of Modern Mongolian]. Ulaanbaatar, 1966]
- Өнөрбаян, Ц.** (2004). *Орчин цагийн монгол хэлний үг зүй*, Улаанбаатар. [Onorbayan, Ts. *Orchin tsagyn mongol khelnii üg züi* [Morphology of Modern Mongolian]. Ulaanbaatar, 2004]
- ТРС**, (1968). *Тувинско-русский словарь*, Москва. [Tuvan-Russian Dictionary. Moscow, 1968]

Цэвэл, Я. (1966). *Монгол хэлний товч тайлбар толь*. Улаанбаатар. [Tsevel, Ya. *Mongol khelnii tovch tailbar toli* [Concise Mongolian Explanatory Dictionary]. Ulaanbaatar, 1966]

Щербак, А.М. (1987). *Очерки по сравнительной морфологии тюркских языков*, Москва. [Shcherbak, A. M. *Essays on the Comparative Morphology of Turkic Languages*. Moscow, 1987]

Товчилсон үг

КТ - Култегиний гэрэлт хөшөө

Т - Тоньюкукийн гэрэлт хөшөө

О - Онгийн гэрэлт хөшөө



Open access: This is an open access article distributed in accordance with the Creative Commons Attribution Non-Commercial (CC BY-NC 4.0) license, which permits others to distribute, remix, build upon this work non-commercially, and license their derivative works on different terms, provided the original work is properly cited, appropriate credit is given, any changes made indicated, and the use is non-commercial. See: <http://creativecommons.org/licenses/by-nc/4.0/>